



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 13 өдөр

Дугаар А/402

Есөнбулаг сум

Хурдан морины уралдаан  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Аймгийн онцгой комиссын 2026 оны 9 дүгээр хуралдааны хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн морин спорт, уяачдын холбооны саналыг харгалзан "АЛТАЙН ХҮЛЭГ" морин спорт уяачдын холбооны 30 жилийн ойн нэрэмжит "Засагт хан-2026" аймгийн зуны хойд бүсийн 9 насны хурдан морьдын уралдааныг 07 дугаар сарын 30-31-ний өдрүүдэд Дарив сумд, Урд бүсийн уралдааныг Цогт сумд, төвийн бүсийн уралдааныг Шарга сумд тус тус зохион байгуулахаар тогтоосугай.

2. Хурдан морины унаач хүүхдүүдэд стандартын шаардлага хангасан хувцас хэрэгсэл өмсгөх, эцэг эх, асран хамгаалагчаас зөвшөөрөл авах, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд хамруулах, шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлж, олон нийтийн хэв журмыг сахиулж, хяналт тавьж тайлагнан ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар (Б.Алтайбаатар), Эрүүл мэндийн газар (О.Баатарчулуун), Цагдаагийн газар (Д.Бүрэнбаатар), аймгийн Морин спорт, уяачдын холбоо (Ц.Саруултөгс) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

